



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/151

Алтанбулаг

Нохой устгал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дүгээр заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дүгээр заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургууль, цэцэрлэг орж эхэлсэнтэй холбогдуулан иргэдээс ирсэн гомдол, саналыг шийдвэрлэх үүднээс нохой устгах ажлыг зохион байгуулахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Зориг), 2 дугаар багийн Засаг дарга (Н.Мөнхзул)-д даалгасугай.

2. Нохой устгалыг хийхэд холбогдох зардал 1,665,200 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.



Н. ОТГОНЦОГТ